

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 02 дугаар сарын 11-ны өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: “**Өөрөө явагч техникийн дугуй (3 багц)**”  
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202012384

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос “**Хүнд даагийн автомашины дугуй (3 багц)**” нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Уг тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

**Багц I:** “Монголросцветмет” ТӨҮГ-т САТ 980F дугуйт ачигчийн дугуй

**Багц II:** “Монголросцветмет” ТӨҮГ-т Сэрээт ачигчын дугуй нийлүүлэх

**Багц III:** “Монголросцветмет” ТӨҮГ-т Автоачигчын дугуй нийлүүлэх

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Туршлага: **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй хэмжээний ижил төстэй бараа, ажил, үйлчилгээг сүүлийн 2 жилд дор хаяж нэг удаа гүйцэтгэсэн байна**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны жилийн санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт, нотариатаар баталгаажуулсан хуулбар хувь ирүүлнэ.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Шаардлагагүй**

Тендерийн хамт **1 -р багцад 1,161,000 төгрөгийн,**

**2 -р багцад 134,000 төгрөгийн,**

**3 -р багцад 940,000 төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ**

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 10:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 10:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 405 тоот өрөө, утас:450060+123

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**